

1997 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД ХИЙСЭН ДҮН
ШИНЖИЛГЭЭ

Н.Урантогтох*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үгс: улс төрийн PR, улстөрч ба сонгогч, сэтгүүл зүй, имиж ба Ерөнхийлөгчийн сонгууль.

1992 оны УИХ-ын сонгуулийн дараа Монголын нийгэм, улс төрийн амьдралд өвөрмөц нөхцөл бүрэлдсэн юм. МАХН үнэмлэхүй ялалт байгуулан, цагаан морин жилийн ардчилсан хувьсгал төгсгөл болсон мэт төсөөлөгдөж байв. Ийм үед УИХ дотор биш, гаднаас хүчирхэг сөрөг хүч бий болгох шаардлага үүссэн юм. Энэ ойлголт нь 1993 оны ерөнхийлөгчийн сонгуулиар шийдэгдэх байв. Түүхэн сонгуульд тухайн үеийн сөрөг хүчин гялалзсан амжилт үзүүлсэн. Түүнийг дагалдан Ерөнхийлөгчийн тамгын газар шинэчлэгдэж, тэр үеийн МҮАН, МСДН-ын “Ардчилсан холбоо” эвслийн сонгуулийн штаб болон хувирсан юм. Ийм институт, зохион байгуулалтгүйгээр сөрөг хүчин нь 1996 оны УИХ-ын сонгуульд ялалт байгуулж чадахгүй байсан. Харин 1997 оны ерөнхийлөгчийн сонгууль бол огт өөр дүр төрх, зураглал дунд өрнөсөн билээ. Төрийн тэргүүний энэ удаагийн сонгуульд нэг талаас анхны УИХ-ын дарга, нөгөө талаас анхны Ерөнхийлөгч, гуравдагч хүчнээс өмнөх парламент (Ардын Их Хурал)-ын дарга нар нэр дэвшин өрсөлдсөн.

Монгол Улсын Үндсэн хууль болон Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу МҮАН, МСДН-ын “Ардчилсан холбоо” эвслээс Ерөнхийлөгч П.Очирбат, МАХН-аас тус намын дарга Н.Багабанди, МУНН-аас УИХ-ын гишүүн Ж.Гомбожав нар нэр дэвшлээ. Тухайн үед “Ардчилсан холбоо” эвслийг бүрдүүлэгч МҮАН 40.000 орчим, МСДН 25.000 гаруй гишүүдтэй байжээ.

П.Очирбат нь БНМАУ-ын АИХ-ын даргаар 1990 оны гуравдугаар сард анх удаа сонгогдсон, ардчилсан сонгуулийн дараах АИХ-ын чуулганаар Ерөнхийлөгчөөр (Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу) улиран (1990 оны есдүгээр сард) сонгогдсон, Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдангуут шинэ Монгол Улсын Ерөнхийлөгчид шууд гулсан (1992 оны 1 дүгээр сард) томилогджээ. Тэрээр 1993 оны ерөнхийлөгчийн сонгуульд бүх ард түмний сонголтоор анх удаа сонгогдсон төрийн тэргүүн юм. Үндсэн хуулийн өөрчлөлт буцан үйлчилдэггүй болохоор 8 дахь жилдээ ажиллаж буй Ерөнхийлөгч П.Очирбат дахин нэрээ дэвшүүлсэн нь хууль эрх зүйн хувьд алдаа болоогүй гэдэг. Түүний 1997 оны ерөнхийлөгчийн сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр нь эдийн засгийн чиг баримжаатай, архи, спиртээс бусад бараа бүтээгдэ-

хүүнийг импортын татвараас чөлөөлөх утгатай байлаа.

Н.Багабанди нь УИХ-ын даргын бүрэн эрхийн хугацаандаа гарт баригдаж, нүдэнд харагдах бодит ажил хийлгүй явсаар МАХН-ыг 1996 оны УИХ-ын сонгуульд ялагдуулсан юм. Гэхдээ Ц.Балдорж тэргүүтэй хэвлэл мэдээллийн магнатуудаар хүрээлүүлсэн Н.Багабанди нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хүч нөлөөтэй, хувь улстөрчийн имиж өндөр байжээ. МАХН-ын гишүүд дэмжигчид, баян бизнесменүүд, сэхээтэн болон оюутан залуусын тодорхой хэсэг ялангуяа малчид түүнийг шүтэн биширнэ.

МУНН нь 20.000 орчим гишүүнтэй ч ар талд нь 281-ийн холбоо ажиллаж байв. Парламентын намын нэр хүнддээ тулгуурлан УИХ-д суудалгүй намуудын эвсэл байгуулахаар оролдсон. Нэр дэвшигч Ж.Гомбожав нь ард түмний дунд нэр хүндтэй, төр засгийн дээд түвшний удирдлагыг ил тод шүүмжилж чаддаг, орон нутгийн малчид, хот суурин газрын борчуудыг өмгөөлсөн улс төр хийж иржээ. Түүний сонгуулийн уриа “тусгаар тогтнол-шударга ёс-эгэл жирийн борчуулын төлөө” гэсэн нь зорилтот бүлгээ шууд тодорхойлсон болно.

1997 оны ерөнхийлөгчийн сонгуулийн онцлог нь зөвхөн энэ гурван хүн нэр дэвшсэнээр хязгаарлагдахгүй. Монголын нийгэм-улс төрийн амьдрал хурцдан, эдийн засгийн хямрал нүүрлэж

байлаа. Ерөнхий сайд М.Энхсайханы бодлого хэт баруунжин, либерал шийдвэр бүр нь “Ардчилсан холбоо” эвслийн төлөө санал өгсөн хүмүүст эргэлзээ тээнэгэлзээ үүсгэж, гутрал цөхрөлд автуулжээ. 1997 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр нэрт эрдэмтэн, хуульч Б.Чимэд “Залуу лидер” клубээр дамжуулан судалгаа хийлгэжээ. Судлаач, дэд доктор Х.Гүндсамбуугийн ахалсан баг эхлээд 742, дараад нь 625 хүний дунд түүврийн аргаар социологийн судалгаа явуулав. Сонгогчдыг “хэний төлөө саналаа өгсөн”, “хэний мөрийн хөтөлбөрийг дэмжиж байгаа”, “маргааш сонгууль болбол хэний төлөө саналаа өгөх” шалгуур тавьж, гурван үзүүлэлтийн хослолоор бодоход аль нэг нэр дэвшигчийг сонгосон атлаа мөрийн хөтөлбөрийг нь биш, нөгөө хоёр нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг сонгосон хүмүүс нэлээд байжээ. Судалгааны баг эдгээр иргэдийг “эргэлзээтэй сонгогч”-оор бүртгэн, хэнийг илүүтэй дэмжихийг тооцоход гайхалтай дүн гарчээ. Хүснэгтээс харвал тухайн цагт Монголын сонгогчдын гуравны нэгийн тэн хагасаас илүү нь “эргэлзээтэй сонгогч” бүлэгт хамрагдах, “ханаралт” нь Н.Багабанди чиглэлтэй байжээ. Үүнийг товч дүгнэвэл манай сонгогчид нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр бус хүнийг нь сонгох төлөвтэй гэсэн үг юм. (Гүндсамбуу.Х, 2001)

Хүснэгт 6					Хүснэгт 8					
Нэр дэвшигчдийг дэмжих төлөв байдал					Сонгогчдын санал өгөх сэдлийн төлөв					
Нэрс	Тууштай дэмжигчид	Эргэлзээтэй дэмжигчид		Бүгд	Н. Багабанди	Хувь	Ж. Гомбожав	Хувь	П. Очирбат	Хувь
Н.Багабанди	66.0	Гомбожав руу	Очирбат руу	100.0	МАХН-аас дэвшсэн	40.0	МУНН-аас нэр дэвшсэн	25.0	"АХ"-ээс дэвшсэн	48.0
		Эргэлзээтэй дэмжигчид		Бүгд	УИХ-ын дарга	14.0	Удирдах зүтгэлтэн	20.0	Анхны ерөнхийлөгч	38.0
Ж.Гомбожав	49.0	Очирбат руу	Багабанди руу	100.0	Хийгүй хүн	13.0	"Морьтой хүн"	18.0	Хээгүй хүн	12.0
		Эргэлзээтэй дэмжигчид		Бүгд	Хүч тэнцүүлэх	26.0	Төлөөллийг нэмэгдүүлэх	18.0	Сонголтыг бататгах	57.0
П.Очирбат	67.0	Багабанди руу	Гомбожав руу	100.0	Залуу хүн	24.0	"Хөдөөний хүн"	80.0	Танил хүн	9.0

Хүснэгт 1. Нэр дэвшигч Н.Багабанди, П.Очирбат, Ж.Гомбожавын тухай судалгааны дүн.

Монгол Улсын Ерөнхийлөгчид горилогч Н.Багабанди сөрөг хүчин МАХН, П.Очирбат эрх баригч “Ардчилсан холбоо” эвсэл, Ж.Гомбожав цөөнх МУНН-аас нэр дэвшив. Судалгаанаас харахад Ерөнхийлөгч П.Очирбатаас сонгогчдын олонх нь нүүр бууруулж, түүний өрсөлдөгч нарт том боломж гарч ирсэн. Анхны Ерөнхийлөгчийн сонгуулийн үед түүний нэр хүнд сонгогчдын дунд өндөр, өрсөлдөгчөө илүүрхэн улиран сонгогдсон. Гэтэл 2 бүрэн эрхийн хугацаанд ажлын арга барилаа өөрчлөөгүй, үр дүн ядмаг байсан тул урьдын байр сууриа хадгалах хүнд байжээ. Үүнийг “Ардчилсан холбоо” эвслийн удирдагчид сайн мэдэж байсан ч дотроосоо нэр дэвших Ерөнхийлөгчөөр сонгогдох насанд хүрсэн хүн байгаагүй, өөр нэр дэвшигч гаднаас олдоогүй

учраас Ерөнхийлөгч П.Очирбатыг дахин нэр дэвшүүлэхээс өөр зам байгаагүй билээ. Тухайн судалгаанаас үзэхэд өндөр настнаас бусад нийгмийн бүлгүүдэд Ерөнхийлөгч П.Очирбатын авах саналын тоо буурах хандлага харагджээ. Тэрээр нийгмийн бүлэг бүрд өөрийн дэмжлэгээ 17.5-34.0 нэгжээр алдсан байв. Энэ бол тухайн үеийн төр засгийн бодлого, үйл ажиллагааны шууд дүгнэлт, улс орон нийгэм эдийн засгийн төлөв хандлагыг илтгэн харуулна.

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн талаарх судалгааг зөвхөн хотод хийсэн бөгөөд нийслэл, орон нутгийн сонгогчдын хооронд зарчмын ялгаа харагдахгүй байсныг сонгуулийн үр дүн харуулсан юм.

Нийгмийн бүлгүүд	Онууд		Зөрөө
	1993	1997	
Эрагтэйчүүд	48.5	30.5	-17.5
Эмэгтэйчүүд	56.0	29.0	-27.0
Хотын захын хорооллынхон	67.0	44.0	-23.0
Залуучууд	51.0	21.0	-24.0
Ид насныхан	59.0	33.0	-26.0
Өндөр настан	39.0	44.0	5.0
Оюутан	49.0	26.0	-23.0
Дээд боловсролтой	44.0	30.0	-14.0
Тусгай дунд боловсролтой	54.0	22.0	-32.0
Бүрэн дунд боловсролтой	53.0	26.0	-27.0
Бүрэн бус дунд боловсролтой	66.0	32.0	-34.0
МАХН-ын гишүүд	36.0	7.0	-29.0

	Н.Багабанди	Ж.Гомбожав	П.Очирбат	Бүгд
Эхний судалгаа	62.7	7.7	29.6	100.0
Сүүлчийн судалгаа	58.0	10.0	32.0	100.0
МАХН-ын судалгаа ¹	51.8	13.0	35.2	100.0
Сонгуулийн дүн ²	60.8	6.6	29.8	97.2

Хүснэгт 2. Сонгогчдын саналын болзошгүй алдагдал ба сонгогчдын саналаа өгөх магадлалын судалгаа.

1997 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар МАХН-аас нэр дэвшигч Н.Багабанди 60.81%:29.81% гэсэн харьцаагаар П.Очирбатыг ялсан нь том амжилт юм. Тухайн цагт ард түмэн амьдрал ахуй, амьжиргааны төвшиндөө сэтгэл нэн дундуур, Улсын Их Хуралд олонх болсон эрх баригч хүчнийг өөрчлөх эрмэлзлэлтэй, дараагийн сонгуулиар хариуцлага тооцох сэтгэл зүйтэй болсон байв. Мөн төрөөс нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэсэн хандлага давамгайлж эхэлжээ.

Олон нийтийн санаа бодол “ардчиллыг хамгаалах”, улс орны үсрэнгүй хөгжлийн загвар “чөлөөт зах зээлд итгэхгүй” болсон байв. Тэд хийсвэр онол, номлол биш бодит ахуй амьдрал, ажилгүйдэл, орлогын бууралт зэрэгт төвлөрчээ. Хамгийн харамсалтай нь эрх баригч “Ардчилсан холбоо” эвслийн дотоод хагарал дээд цэгтээ тулж хэт улс төржилт, олон мянган төрийн албан хаагчийг хоморголон халж байсан нь шинэ улс төрийн хүчний нэр хүнд, байр суурийг эрс бууруулжээ.

1993-1998 оны хооронд “эдийн засаг, амьжиргааны төвшин буурч байгаа” хэмээн үзэгсдийн тоо жил дараалан өсөв. Ийм хандлагатай гэр бүл, иргэдийн тоо 1993 онд 43.7%, 1995 онд 53%, 1996 онд 69%, 1997 онд 75%, 1998 онд 86% хувь болжээ. Энэ нь 100 гэр бүл тутмын 40 нь өөрсдийгөө нэн ядуу, 33 нь ядуу, 17 нь ядуувтар хэмээн үзэж байна гэсэн үг. (Ядуурлыг бууруулах сангийн судалгаа, 1998). Үүнийг баталгаажуулан 1997 оны 5 сард явуулсан “Конрад Аденаурын сан”-гийн судалгаагаар амьдрал ахуй, амьжиргааны асуудлаа төрөөр шийдвэрлүүлэх ёстой гэж 100 гэр бүлийн 34, шаардаж буй 20, мөн ядуучуудыг дэмжих, тэтгэх нам хүчнийг сонгохоо 41 нь илэрхийлж байв. (14 аймаг, 3 хотын 2400-аад хүн оролцжээ) Энэ бүхэн нь 1996 оны сонгуулиар парламентын 76 суудлын 50-ыг авч олонх болсон “Ардчилсан холбоо” эвслийн засгийн газрын бодлого гэж дүгнэгдсэн. Эдийн засгийн эрс шинэчлэл буюу үнэ чөлөөлөлт, хувьчлалыг олон нийт дэмжсэнгүй. Тэд халамжийг эрэлхийлсэн нийгмийн хамгааллын бодлого, хямрал ядуурлаас хамгаалах “ивээн тэтгэгч”, “шинэ удирдагч” хүсэж байлаа. Өөрөөр хэлбэл 1996 оны Улсын Их Хурлын сонгуулийн өмнө олон нийтийн санаа бодол үгүйсгэгч эсэргүүцэгч хандлагатай нь шинэ сонголт хийлгэн “Ардчилсан холбоо” эвсэлд ялалт авчирсан бол 1997 он өөр байв. Ерөнхийлөгчийн сонгуулийн жилд эрс шинэчлэлтээс цочирдсон, айж эмээсэн, аврагч хамгаалагчийг эрэлхийлсэн хүмүүс “Ардчилсан холбоо” эвслээс бүрмөсөн нүүр бууруулжээ. Ард түмэн 1996 оны сонгуулиар П.Жасрайн засгийн газрын хөшин хойрго, хүнд суртал, эдийн засгийн зогсонги байдалд дургүйцсэн бол 1997 оны сонгуулиар М.Энхсайханы засгийн газрын үнэ

чөлөөлөлт, төрийн өмчит компаниудын хувьчлал, мөнгөний хатуу бодлого, цалин үл нэмэх шийдвэрийг эсэргүүцсэн юм.

1 997 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар эдийн засгийн эрс либералчлал, үнэ чөлөөлөлт, өмч хувьчлал, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хэт улс төржилтөөс шалтгаалан төрд дэг журам тогтоогч, хамгаалагч имижтэй сөрөг хүчний лидер ялах нь тодорхой болов. Нэр дэвшигчдийн хувь хүний зан чанарын үзүүлэлтээр Н.Багабанди бусад өрсөлдөгчөөсөө 0.61 пунктээр илүү (Н.Багабанди 1.06, П.Очирбат 0.45, Ж.Гомбожов 0.33) байсан нь түүний нэр хүндийг илтгэнэ. (Сонгууль-97 бага хурлын товхимол, 1997). Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх “Прогноз” төвийн судалгаагаар сонгогчид нэр дэвшигчийн сонгох шалгуурыг шударга зарчимч (47.7%), олон нийтийн санаа бодлыг мэдэрдэг (38.6%), мэдлэг боловсрол ихтэй (29.6%) гэсэн байдлаар эрэмбэлж, Н.Багабанди 41.5%, П.Очирбат 15%, Ж.Гомбожов 7.5% нь тус тус шударга, зарчимч талаараа давуу гэжээ. (Ардын эрх сонин №85(1563), 1997) Нийгмийн тулгамдсан асуудлыг эрэмбэлэхэд олон нийтийн санаа бодол эрх баригч “Ардчилсан холбоо” эвсэлд туйлын хангалтгүй үнэлгээ өгснийг харуулж байв. Иргэдийн олонх нь ардчилсан тогтолцооны үнэ цэн, өөрчлөлтийг биш өдөр тутмын ахуй амьдрал, амьжиргааны түвшиндээ анхаарч сонголт хийжээ. Тухайлбал, нийгмийн тулгамдсан асуудлын нэгдүгээрт ажилгүйдэл 43% /1995 он/, орлогын бууралт 63% /1996 он/, үнийн өсөлт 71% /1997 он/ болсон байв.

МАХН-аас нэр дэвшигч Н.Багабандийн имиж тухайн үеийн Ерөнхийлөгч П.Очирбатаас эрс ялгарах, эсрэг дүр төрх, үзэл санааг илэрхийлэхэд

оршиж байлаа. Тэрээр нийгэм, олон нийтийн эрх ашгийг хамгаалагч, шударга ёс, хууль дээдлэх зарчмыг үндэслэн өмч хувьчлал, банкны салбарын алдаа завхралыг засан товхинуулагч, нийгмийн халамжийн тогтолцоог шинэ шатанд гаргах утга агуулга, санаа бодлыг онцолж байлаа. Ерөнхийлөгч П.Очирбат Монголын үндэсний телевиз дээр тулгуурласан өдөр тутмын албан мэдээ, уулзалт, орон нутгийн томилолт бүхий мэдээлэл сурталчилгааны аргыг баримталсан бол Н.Багабанди ярьдаг бус бичдэг, телевизийн биш сонины лидер байхаар эрмэлзсэн. Нэр дэвшигч Н.Багабанди нь улс орны “эцэг” ямар хүн байх, юу ярьж, хэрхэн харагдах вэ? гэдгийг тод харуулж эрс онцгойрч байлаа. Н.Багабандийн үг үзэл бодол сөрөг хүчний намын лидер, ард түмний эрх ашгийг хамгаалагч, шинэ үеийн онолч, номлогч байв. Ерөнхийлөгч П.Очирбатын “шилжилтийн үеийг цэглэнэ, Амьдралын доройтлыг арилгана” гэсэн уриа нь өнгөрсөн дөрвөн жилд хийсэн ажилтай нь тохирсонгүй.

Н.Багабандийн бүтээсэн имиж нь олон нийтийн амар тайван байдал, дэг журам сахиулагч, хашир тулхтай, хийгүй улс төрч гэдэгт чиглэв. Түүний бий болгосон нэр хүнд нь Монголын улс төрийн ууган хүчин МАХН-ын дарга, сөрөг хүчний удирдагч, төрийн сахилга бат, эмх цэгцтэй бодлогод нэгтгэгдэж байлаа. Тэрээр социалист нийгмийн төрийн тэргүүний “залгамжлагч” байх дүр төрхийг үзүүлж, эрдэм ном, боловсролыг дээдлэгч, буурь суурьтай тулхтай улс төрч, хашир төрийн тэргүүн байх итгэл, үнэмшлийг төрүүлж чадсан. Олон нийтийн санаа бодол эв нэгдэлгүй УИХ-ыг хянах, эрх баригч хүчний бодлого, үйл ажиллагаанд хяналт тавихад чиглэж байлаа. Энэ бол тухайн цаг үед нийгэм олон

нийтийн шаардлага юм. Энэхүү дүр имижийг бий болгоход нэр дэвшигч Н.Багабандийн сурталчилгаа, мэдээлэл харилцааны хандлага, зорилго чиглэж байв. Тэрээр зарчимч нийтлэл, эрс хатуу үг хэллэг, телевизийн бичлэг ашиглан ардчилсан хүчний дотоод зөрчил, эдийн засгийн цочир бодлого, эрс өөрчлөлт, нийгмийн сэтгэл зүйн гурал бухимдал, архидалт, ажилгүйдлийн сөрөг үр дагаврыг тодотгон байр сууриа бэхжүүлсэн.

МАХН-ын дарга Н.Багабандийн хувь хүний дүр төрх, зан төлөв, хөдөлгөөн ч буурь суурьтай, жинхэнэ “Төрийн хүн” гэсэн үнэлэлт, дүгнэлтэд хүргэж байв. 47 настай залуу удирдагчийн сахал бас дуу хоолой, хэл ярианы “өнгө” өөр байсан. Тэрээр гүн ухааны онол, өвөрмөц хэлц үг, ардын сургаалаар дүүрэн ард түмний “эцэг”-ийн дүр төрх бүтээв. Үгийг нухацтай, тогтуун, нэгэн хэмнэлээр өгүүлэх нь хямрал зөрчлийн үеийн хамгаалагч, шударга ёс тогтоогчийн бодит дүр мэт харагдаж байлаа. Тухайн цагт телевизийн тоо цөөн, орон нутагт үндэсний радио гол хэвлэл мэдээллийн хэрэгсэл болж байсан нь ярианы өнгө, хэмнэл онцгойрсон Н.Багабандид гайхалтай нөлөө үзүүлсэн байдаг. Сэтгүүл зүй, PR-ын талаас үзвэл 1997 он нь сонин-радиоогийн “ноёрхол”-ын үе тул Н.Багабандийн имиж бүрдүүлэлтэд эергээр нөлөөлжээ. Хэвлэлийн хүрээлэн 1997 оноос “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” тайлан судалгааг гаргаж эхэлсэн. Тухайн үед 197 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байжээ. Энэхүү сонгуульд МУНН-аас нэр дэвшигч Ж.Гомбожав нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд, бодлого үйл ажиллагаа, сонгуулийн сурталчилгаагаар хоцрогдож байв. Тэрээр “тусгаар тогтнол-шударга ёс-эгэл жирийн борчуулын

төлөө” уриа дэвшүүлэн улс төрийн популизм хийж байлаа. Засгийн Газрын 1997 онд гарсан буруу хүрдтэй автомашин импортлохгүй гэсэн тогтоолыг эсэргүүцэн хил дээр очин уулзалт хийнэ. “Хил дээр машин овоорлоо, оруул” гэсэн мэдэгдэл нь телевиз, өдөр тутмын сониноор олонтоо гарна.

Ж.Гомбожав нь анхны ардчилсан сонгуулиар байгуулагдсан 430 депутаттай Ардын Их Хурлын даргаар ажиллаж, анхны Ерөнхийлөгчийг сонгох, Улсын Бага Хурлыг байгуулах түүхэн үйл хэргийн хөтөч хийсэн, 1992-1996 оны парламентад Улсын Их Хурлын дэд даргаар ажилласан, 1996-2000 онд УИХ-ын гишүүнээр сонгогдсон улс төрч байв. Түүний хашиж явсан албан тушаал, нэр хүнд нь бодитой байсан тул хил дээр очин импортын автомашинуудыг нэвтрүүлэхэд саад гарсангүй. Удалгүй Засгийн Газрын тогтоол ч хүчингүй болж цуцлагджээ. Нэр дэвшигч Ж.Гомбожав үүнийгээ сонгуулийн сурталчилгааныхаа гол мэдээлэл, буянт үйл хэрэг мэтээр сурталчилсан. Тэрээр энэ цаг үеийг дүгнэхдээ:

“1992-1996 он манай орны хувьд хүнд жилүүд байсан. Далан жил ажиллаж, тусалж байсан нөхрүүдээсээ дэмжлэг тусалцаа бараг авахаа больж, эх орны үйлдвэрүүд тогтмол ажиллаж, ард түмнээ өргөн хэрэгцээний бараагаар хангаж чадахгүй байв. Дэлгүүрийн лангуун дээр бор давс, гоймон хоёроос өөр элбэг дэлбэг бараа байхгүй. Улаанбаатар хот гэрэл, ус, автобусны байнгын гачигдалтай байсан. УИХ, Засгийн газар ард түмэнтэйгээ хамтран бүсээ чангалсны үр дүнд 1994-1995 оны үеэс зарим ахиц өөрчлөлт гарч билээ” (Ж.Гомбожав: Онгоцоор нисэж явахдаа дуудагдаж, буцаад ирж байлаа, 2020) гэжээ.

Түүний ганц амжилт нь өөрийн төрсөн нутаг Сүхбаатар аймагт 34.02%-ийн санал авсанд оршино. Нэр дэвшигч Ж.Гомбожавт улс төрийн гуравдагч хүчний төлөөлөл, төрийн ажлын дадлага туршлага, моринд дуртай монгол эр хүн гэдгээс өөр үнэт зүйл “үгүй” байв. Тухайн цагт эрх баригч “Ардчилсан Холбоо” эвслийн бодлого үйл ажиллагааг хурцаар шүүмжлэгч, шударга ёс үнэнийг хамгаалагч хүн үгүйлэгдэж байсан. Харамсалтай нь гуравдагч хүчний нэр дэвшигчид боломж хязгаарлагдмал байжээ. Нэр дэвшигч нь улс төрийн нам сольсон (МАХН-ын гишүүн байсан), нийгмийн бүх бүлгийн эрх ашгийг илэрхийлэгч бус (ядуусын эрх ашгийг хамгаална), улс орон, нийгэм эдийн засаг, улс төрийн бодлого, өөрчлөлт шинэчлэлийн байр суурьгүй (баячууд, шударга бус, өмч хувьчлалын эсрэг) популист амлалтын хүрээнд сурталчилгаагаа явуулж байв. Телевиз, радиогоор ч харагддаггүй, ухуулга сонин хэвлэл ч тун цөөн ширхэг тараасан зэрэг нь нийгэм олон нийтийн зүгээс лидер хэмээн хүлээн зөвшөөрөх бодит шалтгаан, эрэлт байсангүй. Тухайн цаг үеийн Монголын нийгэм, улс төрийн онцлог нь төрийг дээдлэх үзэл ноёлж байв. Хүн ам цөөн, эдийн засаг ядмаг, телевизийн тоо хэт цөөн байсан нь гуравдагч хүчний орон зайг хязгаарлаж байсан юм. Ийм гуравдагч хүчний нэр төдий төлөөлөл, хувь улс төрчийн нэр дэвших оролцоо нь 2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль хүртэл үргэлжилсэн. Нэр төдий гориллогч нь “гол тоглогч”, ялах нь тодорхой лидерийн үзэл санаа, байр суурийг давтах, нэмэн дэлгэрүүлэх хувь зохиолтой ба нутаг ус, дэвшүүлж буй намын дэмжлэгээс цааш гардаггүй юм.

1997 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн нэг онцлог нь телевизийн мэтгэлцээн олон нийтийн сонголтод

шууд нөлөөлдгийг харуулав. Сонгуулийн халз мэтгэлцээн бол телевизийн бусад нэвтрүүлгээс өвөрмөц ялгаатай, нэр дэвшигчдэд улс төрийн байр суурь, улс орны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлого, арга замын тухай санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгодог. Нөгөө талаар сонгогчдын анхаарал татах, иргэдийг санал хураалтын өмнө мэдээлэл, мэдлэгтэй болгон, өөрийнхөө төлөөллийг сонгох зөв шийдвэр гаргахад тусалдаг.

Манай улс сонгуулийн халз мэтгэлцээнийг анх 1993 онд зохион байгуулсан. Сонгуулийн халз мэтгэлцээн нь улс орон бүрд улс төрийн компани ажлын гол бүрэлдэхүүн хэсэг болон хөгжиж байна. Сонгуулийн халз мэтгэлцээнийг 1848 онд АНУ-ын Иллионис мужийн Сенатын мэтгэлцээнээс эхэлсэн гэж үздэг. Мэтгэлцэгч нь АНУ-ын Конгрессын гишүүн асан Абрахам Линкольн, АНУ-ын сенатор Стефен Дуглас нар байжээ. Долоон цуврал мэтгэлцээнийг тухайн оны наймдугаар сарын 21, 27, есдүгээр сарын 15, 18, аравдугаар сарын 7, 13, 15-ны өдрүүдэд Иллионис мужийн долоон дүүрэгт зохион байгуулжээ. Цуврал мэтгэлцээн нь тус бүр гурван цаг үргэлжилсэн гэдэг. Халз мэтгэлцээний гол сэдэв нь боолчлол, эвлэлдэн нэгдэх үзэл санааны тухай байлаа. Харин албан ёсны Ерөнхийлөгчийн сонгуулийн халз мэтгэлцээн 1948, 1956 онуудад болж байжээ.

Сонгуулийн сурталчилгааг шинэ шатанд гаргасан телевизийн анхны халз мэтгэлцээн 1960 онд Жон Кеннеди, Ричард Никсон нарын дунд NBC телевизийн шууд нэвтрүүлгийн танхимд зохион байгуулагдсан түүхтэй. Харамсалтай нь 1964, 1968, 1972 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр АНУ-д халз мэтгэлцээн болоогүй бөгөөд 1976 онд дахин сэргээж байв. Гэхдээ л 1980,

1984 оны зохион байгуулалтад саад бэрхшээл их гарчээ. Улмаар 1987 онд Ерөнхийлөгчийн халз мэтгэлцээний комисс (Commission on Presidential Debates) байгуулж, тогтмолжсон байна. Энэхүү комисс нь дан ганц төрийн байгууллага биш бөгөөд олон нийтийн корпорацийн хувиар өнөөг хүртэл Ерөнхийлөгчийн халз мэтгэлцээн зохион байгуулдаг юм.

Мэтгэлцээн бол төвийг сахисан, нэр хүндтэй индэр бөгөөд улс төрийн намын удирдлага, нэр дэвшигчдийг олон нийтийн хойморт урин залдаг. Хөтлөгч, сонгогч болон өрсөлдөгчдийн бие биедээ тавьсан асуулт хариулт нь нэр дэвшигчдийг харьцуулах боломжийг шууд олгодог. Нэр дэвшигчид телевизийн мэтгэлцээнийг харилцан тохирсон дүрмийн дагуу хийдэг бөгөөд хамгийн чухал нь шударга байдлыг хангахын тулд ярих хугацааг хязгаарладаг. Мэтгэлцээн нь радио, телевиз, интернэтээр олон нийтэд хүрч болно. Сонгуулийн халз мэтгэлцээн нь радиогоор нэр хүнд олсон ч 1960 оны телевизийн мэтгэлцээний дараа үр нөлөө нь улам бүр нэмэгдсэн байв. Одоог хүртэл халз мэтгэлцээн нь телевизийн хамгийн их үзэгчтэй, нөлөө бүхий сонгуулийн нэвтрүүлэг хэвээр байна. Улс төрийн утгаараа мэтгэлцээн нь зөвхөн намын бодлого, хувь нэр дэвшигчдийн мэдлэг чадвар хандлага эсвэл өрсөлдөгч талуудын байр суурь гэсэн олон хэлбэрүүдтэй. Ардчилсан тогтолцоотой улс орнуудад мэтгэлцээн нь олон талаараа ашиг тусаа өгдөг. Тэр дундаа сонгогчдод саналын хуудас бөглөхийн өмнө мэдээлэлтэй байхад тусалдаг. Өнөөг хүртэл улс төр, нийгэм соёл, хөгжлийн хувьд өөр өөр онцлогтой дэлхийн 60 гаруй орон улс төрийн мэтгэлцээн зохион байгуулж хөгжүүлж иржээ.

Мэтгэлцээнийг нэр дэвшигчдийн хувийн шинж чанар, шашин шүтлэг, үндэс угсааг бус олон нийтийн анхаарал хандуулж буй асуудалд бодлогын шийдэл гаргахад чиглүүлдэг. Мөн хүний эрх хамгаалах, сонгуулийн амлалтаа хэрхэн биелүүлсэн зэрэгт зориулан хийнэ. Нэг улс төрийн хүчин нь хэвлэл мэдээллийн салбарт давамгайлж буй орнуудад мэтгэлцээнээр бүх нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө хүргэх, өөрийгөө таниулах боломж олгогдог. Аль ч нэр дэвшигчид улс төрийн бодлогын асуудлаар өөрийн байр сууриа илэрхийлэх, өрсөлдөж буй албан тушаалд ажиллах чадвартай гэдгээ харуулах боломж бий. Зарим нэр дэвшигч телевизийн мэтгэлцээнээр илүү сайн удирдагч, зохион байгуулагч болохоо нотлон харуулж чаддаг. Харин иргэдийн хувьд сонгуулийн үеэр нэр дэвшигчид нэг дор хамтдаа байх нь харьцуулалт хийх ховор боломж олгодог.

Мэтгэлцээнээр нэр дэвшигчийн улс төрийн байр сууриас гадна өрсөлдөгчийн дайралтад үзүүлж буй сэтгэл хөдлөлийг мэдрэх

боломжтой. Сонгуулийн сурталчилгаанаас ялгаатай нь нэр дэвшигчид тайзан дээр мэтгэлцээний дүрэмд заасны

дагуу бүтээлч, хүндэтгэлтэй байдлаар ярилцаж гар барих, тэврэх, эрч хүчтэй харагдах зэрэг эерэг мессеж илгээнэ.

Мэтгэлцээн нь сонгуулийг тайван замаар, олон нийтэд нээлттэй явуулах боломж олгон, сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөх, сонгуулийн маргааныг хуулийн хүрээнд шийдвэрлэхийг уриалдаг. Мөн тодорхой хугацааны дараа сонгогдсон улс төрчөөс иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагууд мэтгэлцээний бичлэг, хэвлэлийн сурталчилгааг эш татах замаар хариуцлага нэхэх боломжтой. Зарим улс оронд сонгогдсоноос хойш ямар үр дүнтэй ажил хийснийг нь тодруулах зорилгоор сонгуулийн дараах мэтгэлцээнийг зохион байгуулж эхэлсэн. 1997 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээнд дүн шинжилгээ олон зүйл тодорхой

«

Мэтгэлцээнийг нэр дэвшигчдийн хувийн шинж чанар, шашин шүтлэг, үндэс угсааг бус олон нийтийн анхаарал хандуулж буй асуудалд бодлогын шийдэл гаргахад чиглүүлдэг.

Мэтгэлцээний үеэр

Н.Багабанди “21-р зууны хөгжлийн чиг хандлага хүнийг төвдөө чиглэсэн бодлого байна.

Аль нэг эдийн засаг, улс төр, ашиг орлогын төлөө биш эцсийн дүнд хүндээ зориулагдах учиртай. Би ард түмний

тодорхой нэг хэсгийг тасалж аваад төлөөлөх бодолгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч бол ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч. Мерседес унаж байгаа нь ч, махгүй хонож байгаа нь миний хувьд адилхан байх болно” хэмээн нийгмийн бүлэг бүрд хандсан үгс хэлж, ухуулж байлаа. Гэтэл нэр

дэвшигч П.Очирбат “би түрүүн Н.Багабандийн хэлснийг л хэлчихмээр санагдаад явчхаж байгаа юм. Сонгогчид нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр хэр зэрэг гэдгийг өөрсдөө харьцуулан шийдвэрлээсэй” гэж ялагдалтайгаа эвлэрсэн

мэт байр суурь, хандлага илэрхийлжээ

хийж үзвэл харагдана.

МАХН-аас нэр дэвшигч Н.Багабанди “иргэний төлөө төр, хүний төлөө нийгэм” уриатай сонгуульд оролцсон. Харин Ерөнхийлөгч П.Очирбат “шилжилтийн үеийг цэглэнэ, амьдралын доройтлыг арилгана” гэсэн уриа дэвшүүлэв. Мэтгэлцээнд оролцож байх үед Н.Багабанди “21-р зууны хөгжлийн чиг хандлага хүнийг төвдөө чиглэсэн бодлого байна. Аль нэг эдийн засаг, улс төр, ашиг орлогын төлөө биш эцсийн дүнд хүндээ зориулагдах учиртай. Би ард түмний тодорхой нэг хэсгийг тасалж аваад төлөөлөх бодолгүй байна. Монгол Улсын Ерөнхийлөгч бол ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч. Мерседес унаж байгаа нь ч, махгүй хонож байгаа нь миний хувьд адилхан байх болно” хэмээн нийгмийн бүлэг бүрд хандсан үгс хэлж, ухуулж байлаа. Гэтэл нэр дэвшигч П.Очирбат “би түрүүн Н.Багабандийн хэлснийг л хэлчихмээр санагдаад явчхаж байгаа юм. Сонгогчид нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр хэр зэрэг гэдгийг өөрсдөө харьцуулан шийдвэрлээсэй” гэж ялагдалтайгаа эвлэрсэн мэт байр суурь, хандлага илэрхийлжээ.

Улс төрийн тэгш бус нөхцөлтэй, төрийн эрхийг 2 том нам ээлжлэн барьдаг оронд жижиг намын нэр дэвшигчид амжилт үл олно. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол гардаг, төрийн өндөр албан тушаал хашиж буй хүмүүстэй нэр дэвшигч Ж.Гомбожав нүүр тулсан. Түүнд улс орон даяар дуу хоолойгоо хүргэх ганцхан боломж байсан нь телевизийн мэтгэлцээн байв. Харамсалтай нь хэт нуршуу, товч тодорхой бус, асуудал бэрхшээлийг хөндөх хэдий ч гаргалгаа шийдэл байхгүй ярьсан.

Халз мэтгэлцээний агуулгыг бүхэлд нь харвал цэл залуу, эрч хүчтэй, сөрөг хүчний удирдагч Н.Багабанди эрс

ялгарч чадсан. Сонгуулийн сурталчилгааны үеэр телевизийн 4 төрлийн нэвтрүүлэг байдаг. Энэ нь мэдээ, цаг үеийн сурвалжилга нэвтрүүлэг, мэтгэлцээн, улс төрийн намуудын төлбөртэй болон үнэгүй сурталчилгааны нэвтрүүлэг юм. Тухайн үед Ерөнхийлөгч П.Очирбат, УИХ-ын гишүүн, МАХН-ын бүлгийн дарга Н.Багабанди нарын тухай мэдээ сурвалжилга “цаг үеийн үйл явдал” нэрээр Монголын Үндэсний телевизээр олонтоо гарч байв. Сонгуулийн мэтгэлцээн нь телевизийн хамгийн үзэгч ихтэй, сонирхолтой хөтөлбөр тул сэтгүүл зүйн мэргэжлийн хэм хэмжээг зайлшгүй баримтлах ёстой. Сэтгүүл зүйд аль нэг талыг баримтлалгүй, ялгаварлан гадуурхахгүйгээр мэдээллээ хүргэх нь үзэгч, сонсогч, уншигчдад итгэл найдварыг бий болгодог. Тэнцвэртэй байх нь мэтгэлцээнд баримтлах хамгийн чухал зарчим юм. Сэтгүүлч өөрийн байр суурийг гаргахгүй байхаас гадна асуултаа урьдчилан бэлтгэсэн, товч байх тусам олон нийт сайн хүлээж авдаг. Шууд нэвтрүүлгийн үеэр хүн санамсаргүйгээр бодит байдал, чухал мэдээлэл, үнэнээ хэлчихдэг.

1997 оны Ерөнхийлөгчийн сонгуульд эв нэгдэлгүй нам ялалт байгуулах боломжгүй гэдгийг “Ардчилсан холбоо” эвсэл нотолсон. Ердөө жилийн өмнө буюу 1996 оны парламентын сонгуульд муу ажилласны улмаас МАХН, түүний дарга Н.Багабанди ялагдал хүлээсэн. Гэтэл ганцхан жилийн дараа яг тэр багаараа ерөнхийлөгчийн сонгуульд ялна гэдэг нь иргэдийн итгэл нэг эргэвэл ямар туйлирамтгай гэдгийг харуулав. Олон нийт итгэл даах, буурь суурьтай МАХН-ын төлөөлөлд найдсан. Энэ цаг үед сонин хэвлэл, телевиз мэдээлэл сурталчилгааны гол эх сурвалж байлаа.

Эшлэл

1. Гүндсамбуу. Х. Өнөөгийн Монголын улс төрчид уруудалт, өгсөлт. “Шинэ толь” сонин. №34. 2001.
2. Ядуурлыг бууруулах сангийн судалгаа. 1998.
3. “Сонгууль-97” бага хурлын товхимол УБ.1997. 24-р тал”
4. “Ардын эрх сонин”. 1997. №85(1563).
5. Ж.Гомбожав: Онгоцоор нисэж явахдаа дуудагдаж, буцаад ирж байлаа// “Монголын үнэн” сонин. 2020.10.27.
5. “Ардын эрх сонин”. 1997. №85(1563).
6. “Монголын үнэн” сонин. 2020.10.27.

Summary

This article discusses public relations' features of each three candidates for the presidential election of Mongolia in 1997. During The Democratic Union Coalition proved that a party without unity could not win the 1997 presidential election. Just a year ago, the MPRP and its chairman, N.Bagabandi, lost the 1996 parliamentary elections due to poor performance. However, the fact that the same team won the presidential election a year later shows how important building the people's trust through PR. The public relied on a trustworthy and serious MPRP representative. At that time, newspapers and television were the main sources of information and advertising.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Гүндсамбуу. Х. Өнөөгийн Монголын улс төрчид уруудалт, өгсөлт. УБ. 2001.
2. Өнөрбаяр Г. Улс төрийн PR. УБ. 2004.
3. Болд-Эрдэнэ Б. Олон нийтийн харилцаа. УБ. 2006.
4. Ядуурлыг бууруулах сангийн судалгаа. 1998.